

**ИНЖЕНЕРИЙН ХИЙЦТЭЙ ГҮН ӨРМИЙН
ХУДАГ ШИНЭЭР ГАРГАХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Байршил: Жаргалант сум Нам толгой 1 дүгээр баг

Инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргахад тавигдах шаардлага: Инженерийн гүн өрмийн худаг гаргах ажлыг "Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага "MNS" 8088:2010 стандартыг мөрдөж "Усны мэргэжлийн байгууллага" хийж гүйцэтгэнэ.

№	Үзүүлэлтүүд
1.Цооног өрөмдөх, тоноглох шавхалт	
1.1	Геофизикийн судалгаа хийж, худгийн байршлыг эцэслэн тогтоох
1.2	Цооногийн ашиглалтын ундрага нэг цагт 2-6 м ³ ус өгөх хүчин чадалтай байна.
1.3	Суултын яндангийн материал нь ган, хуванцар хоолой байх ба ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн олон улсын чанарын гэрчилгээтэй байна.
1.4	Шүүрийн яндангийн материал нь ган, хуванцар хоолой байх ба ундны усанд хэргэлэхэд зөвшөөрөгдсөн олон улсын чанарын гэрчилгээтэй байна
1.5	Цооногоос ус өргөх хоолойн диаметр 32 мм-ээс багагүй, материал нь ган хоолой байна.
1.6	Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ 10-15 мм-ээс томгүй байна
1.7	Тунгаагуурын гүн: 2 м-ээс багагүй
1.8	Худгийн шавхалт хийж цэвэрлэх: 24 цагаас багагүй байх
1.9	Усны чанарын сорилт авах, шинжилгээ хийлгэх
1.10	Худгийг түр хугацаанд тагаар тоноглох
2.Худгийн барилга, усан сан, мал услах онгоц, талбай	
2.1	Худгийн барилга: <ul style="list-style-type: none"> • Хэмжээ /дотор талдаа/: 3мх3м, ханын өндөр шалнаас дээш 2 м • Материал: тоосго, блок, мод. • Ханыг дотор талаас нь шавардаж. цагаан өнгөөр будна • Хаалга нь 3 мм зузаантай төмөр хаалга байна. • Худгийн барилгын суурийн гүн 0.5 метрээс багагүй байна • Худаг нь дээд талдаа 30 смх30 см нээлхийтэй байна Нээлхий нь цооногт засвар, үйлчилгээ хийхэд зориулагдана • Худгийн цонх нь 40х50 см хэмжээтэй, хамгаалалтын төмөр сараалжин хаалттай байна. /Цонхны байрлал нь мал услах онгоцны харалдаа байна./ Стандартад заасан худгийн барилгын хэмжээнд тохируулан контейнер барилга суурилуулж болно. Худгийн барилга гадна талдаа 30 см өргөнтэй налуу хаявчтай байна. <ul style="list-style-type: none"> • Худгийн барилгын дээвэр нь төмөр материалаар хийгдсэн байна
2.2	Мал услах онгоцонд ус хүргэх хоолой нь 50 мм диаметртэй, гаднах хананаас 2м урттай гадагшилсан ган хоолойг цонхны доод талд гаргана.
2.3	Ундны ус авах хоолой нь 50 мм диаметртэй ган хоолойг цонхны доод талд гаргана. /ундны ус авах тохиромжтой хэмжээгээр уртыг сонгоно./
2.4	Генератор /мотор/-ын утааг гадагшлуулах зорилгоор 40 мм-ийн диаметртэй цоорхойг генераторын янданд тохируулан тохиромжтой байрлалд гаргана.
2.5	
3. Мал услах онгоц, талбай	
3.1	Мал услах онгоц. <ul style="list-style-type: none"> • Хэмжээ 9 м-ээс багагүй урттай байна

	<ul style="list-style-type: none"> • Материал: 400 мм-ийн голчтой хагас цилиндр ган хоолой буюу цутгамал төмөр бетон • Онгоцыг худгийн барилгаас 1-2 хэмийн налуутайгаар 2м-ийн зайд байрлуулна. • Онгоцны адагт үлдэгдэл усыг юүүлэх жижиг нээлхий гаргана. Нээлхийг онгоцонд ус өгөх үед эргэдэж хаадаг байхаар хийнэ. • Усан сангаас мал услах огоцонд ус дамжуулах хоолойг усан сангийн доод ёроолын усыг бүрэн шавхахаар байрлуулан гагнана. • Онгоцыг ган яндангаар хийсэн үед ирмэгийг аюулгүй болгож засна.
3.2.	<p>Мал услах талбай:</p> <ul style="list-style-type: none"> • Хэмжээ: Мал услах онгоцны хоёр талд 1.0 м урттай. 0.5 м өргөнтэй цементэн хавтангаар мал услах талбай хийж суурилуулна. • Материал 150 маркаас доошгүй чанартай цемент хэрэглэнэ. Талбайг хийхдээ цементийг төмөр тороор хүчитгэсэн байна. • Мал услах талбай нь худгийн барилга болон мал услах онгоцтой харьцуулахад бага зэрэг налуутай бөгөөд үлдэгдэл ус болон асгарсан ус юүлэгдэх зориулалттай байна.
<u>4. Худгийн ус шахуурга, ус өргөх хоолой, шүүр яндан</u>	
4.1	<p>Худгийн шахуурга: ISO 1509001:2015 стандартын шаардлага хангасан байх. Ус шахуургын хөдөлгүүр нь олон улсын EN60335-1, 2012+A11 2014, AC:2014, стандартын шаардлага хангасан, 3 салаа цахилгааны утастай, утас нь ус шахуургын удирдлагын самбараар дамжин цахилгаанд холбогдоно. Ус шахуурга стандартад нийцсэн сүүлийн үеийнх байх. /<u>Гэрчилгээг хавсаргах</u>/ Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх.</p>
4.2	<p>Цахилгааны утас: IEC 60227-5 болон ISO9001:2015 чанарын шаардлага хангасан VCTF эсвэл түүнтэй дүйцэхүйц загварын 3 салаатай, ус чийгнээс хамгаалагдсан давхар бүрээстэй, цооногт устай нөхцөлд ашиглах шаардлагыг хангасан байх, утас нь ус шахуургаас хянах самбар хүртэл залгаасгүй ургэлжилсэн байна. Ус өргөх хоолойнд 2 тутамд хавчиж тогтооно /скоч, туузаар ороож болохгүй/</p>
4.3	<p>Ус өргөх хоолой: GB/T 18997.1-2002 стандартын шаардлага хангасан, зориулалтын түүхий эдээр хийгдсэн, доод тал нь 1.0 ТПас-с багагүй даралт даах чадвартай, цагаан өнгийн, дотор давхарга нь тунгалаг, ундны ус дамжуулах зориулалттай байх Хоолойн гадна диаметр 32 мм-с багагүй байх.</p>
4.4	<p>Хянах самбар: Асаах, унтраах товчлууртай, ус шахуурга ажиллаж буйг /улаан гэрлээр асаах дохиололтой, ус шахуурга ажиллуулах асаагууртай байх/.</p>
4.5	<p>Худгийн шүүр яндан: 100 м хүртэл гүнтэй цооног дахь шүүрийн яндангийн гадаад диаметр нь 127 мм-ээс дээш байна Хуванцар хоолойн нь анхдагч түүхий эд ашиглаж үйлдвэрлэсэн, MNS5544:2007 чанарын шаардлага хангасан, тохирлын гэрчилгээтэй байх, ундны усны стандартын шаардлага хангасан, лабораторийн шинжилгээтэй байна. Эргэлтэт, цохилтот өрөмдлөгийн аргаар өрөмдсөн цооногт дахь шүүрийн янданг ус нэвтрүүлэх шүүрийг зориулалтын төхөөрөмжөөр хөндлөн байдлаар нэг эгнээнд 8-10 ширхэг, 40-80 мм хэмжээтэй цуулбарлан ашиглаж болно. Хоолойн зузаан нь 3 мм-ээс багагүй байна.</p>
<u>5.Худаг хүлээлгэн өгөх</u>	
5.1	Талбайг цэвэрлэх:

	/Өрөмдлөгийн шлам, барилгын болон ахуйг хог гэх мэт/
5.2	Худаг, ус шахуурга, жижиг оврын генератор ажиллуулах, үйлчилгээ хийх талбайн сургалт хийх.
5.3	Худгийн паспорт 2 хувь бэлтгэж баталгаажуулан сумын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгнө. Ашиглалтын зааврыг бэлтгэж, ашиглалтанд хүлээлгэн өгөх.

Монгол Улсын Хөдөө аж ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2005 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 101,189, 194 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Инженерийн хийцтэй, худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам”-ыг мөрдөнө.

_____оОо_____